



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/111/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn
Дорноговь аймаг
2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn
Аудитор: Л.Равдандорж
Цахим хаяг: Ravdandorjl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Ауд. 02.02 № 1-6/33

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН 5 ДУГААР
БАГИЙН ЗАСАГ ДАРГА Ц.ГАНЗОРИГ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

440020448

Үүрэг, хариуцлага

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын алба Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,986,980.19</u>	<u>3,634,680.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	6,986,980.19	3,634,680.00
354	Хангамжийн материал	6,986,980.19	3,634,680.00
35410	Бичиг хэргийн материал	176,300.19	283,000.00
35420	Аж ахуйн материал	6,810,680.00	3,351,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>610,579,110.23</u>	<u>632,301,144.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	610,579,110.23	632,301,144.25
392	Биет хөрөнгө	592,435,110.23	612,717,977.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	655,591,538.88	695,016,305.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(129,344,387.34)	(134,963,729.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,090,000.00	50,190,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,790,000.00)	(41,040,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,457,867.00	54,616,867.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,237,311.76)	(30,112,760.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,707,790.00	27,007,790.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,969,276.16)	(13,349,004.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,629,050.78	9,629,050.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,700,161.17)	(4,276,540.97)
393	Биет бус хөрөнгө	18,144,000.00	19,583,166.72
39301	Программ хангамж	1,264,500.00	2,991,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,264,500.00)	(1,552,333.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,144,000.00	18,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>617,566,090.42</u>	<u>635,935,824.25</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,576,434.27</u>	<u>1,693,184.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,576,434.27	1,693,184.90
413	Өглөг	2,576,434.27	1,693,184.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.90	1,693,184.90
4136	Бусад өглөг	2,576,433.37	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,576,433.37	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>614,989,656.15</u>	<u>634,242,639.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	614,989,656.15	634,242,639.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	156,550,131.63	156,550,131.63
51101	Өмч: - төрийн	156,550,131.63	156,550,131.63
512	Хуримтлагдсан үр дүн	441,828,638.21	474,346,312.13
51210	Өмнөх үеийн үр дүн	441,828,638.21	455,093,328.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	19,252,983.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,610,886.31	3,346,195.59

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>617,566,090.42</u>	<u>635,935,824.25</u>
---	--	------------------------------	------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	636,296,493.00	231,258,754.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	466,589,433.00	50,681,654.15
120	Нийтлэг татварын бус орлого	466,589,433.00	50,681,654.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	466,589,433.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	466,589,433.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		50,681,654.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	169,707,060.00	180,577,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,108,560.00	854,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,858,560.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		854,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	148,598,500.00	179,723,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	148,598,500.00	179,723,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	198,195,245.43	212,005,770.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	198,195,245.43	212,005,770.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,195,245.43	209,356,236.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,623,270.81	135,244,505.74
210101	Үндсэн цалин	91,305,944.90	114,244,505.74
210105	Гэрээт ажлын хөлс	24,317,325.91	21,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,134,524.93	17,511,235.26
210201	Тэтгэврийн даатгал	13,624,524.93	12,768,764.35
210202	Тэтгэмжийн даатгал	176,400.00	1,353,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	192,600.00	484,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	65,700.00	104,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	75,300.00	2,800,770.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,903,883.71	13,643,475.16
210301	Гэрэл, цахилгаан	879,580.81	1,276,443.16
210302	Түлш, халаалт	10,974,302.90	10,317,032.00
210303	Цэвэр, бохир ус	2,050,000.00	2,050,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,034,259.50	7,367,900.19
210401	Бичиг хэрэг	1,406,868.00	1,172,900.19
210402	Тээвэр, шатахуун	2,986,603.00	2,999,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,482,588.50	1,441,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,158,200.00	1,753,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	875,000.00	500,000.00

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	875,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	657,400.00	-
210702	Дотоод албан томилолт	657,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,648,013.00	500,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,348,013.00	200,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	40,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,000.00	220,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,318,893.48	34,589,020.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	170,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,318,893.48	34,418,620.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,649,534.47
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,649,534.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,649,534.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>438,101,247.57</u>	<u>19,252,983.20</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,102,499.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,102,499.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,102,499.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>436,998,748.57</u>	<u>19,252,983.20</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>169,707,060.00</u>	<u>180,577,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>169,707,060.00</u>	<u>180,577,100.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,108,560.00	854,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,858,560.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		854,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	148,598,500.00	179,723,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	148,598,500.00	179,723,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>169,707,060.00</u>	<u>178,718,100.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>169,707,060.00</u>	<u>178,718,100.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>169,420,515.81</u>	<u>176,068,565.53</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,547,355.81	137,151,310.02
210101	Үндсэн цалин	84,067,355.81	116,151,310.02

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210105	Гэрээт ажлын хөлс	24,480,000.00	21,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,766,700.00	18,180,864.35
210201	Тэтгэврийн даатгал	6,903,500.00	12,768,764.35
210202	Тэтгэмжийн даатгал	1,581,200.00	1,353,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,521,800.00	1,082,380.00
210204	Ажилгүйдлийн даатгал	826,600.00	270,620.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,933,600.00	2,706,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,590,500.00	11,950,291.16
210301	Гэрэл, цахилгаан	846,902.00	1,276,443.16
210302	Түлш, халаалт	10,693,598.00	8,779,240.00
210303	Цэвэр, бохир ус	2,050,000.00	1,894,608.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,851,000.00	6,441,100.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,700,000.00	2,999,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,151,000.00	1,441,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,380,697.00	641,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	141,000.00
210602	Тавилга	4,080,697.00	-
210604	Урсгал засвар	6,300,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	657,400.00	-
210702	Дотоод албан томилолт	657,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,626,863.00	1,454,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,326,863.00	1,154,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	40,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,000.00	220,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	286,544.19	2,649,534.47
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	286,544.19	2,649,534.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	286,544.19	2,649,534.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>1,859,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<u>1,859,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	<u>1,859,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,859,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,159,000.00
223001	Бусад хөрөнгө	-	700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(1,859,000.00)</u>

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	4,829,889.64	177,990,907.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	4,829,889.64	177,990,907.58
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	436,998,748.58	436,998,748.58
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	441,828,638.22	614,989,656.16
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	441,828,638.21	614,989,656.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	13,264,690.72	13,264,690.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	455,093,328.94	628,254,346.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(13,264,690.72)	-	(13,264,690.72)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	19,252,983.20	19,252,983.20
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,550,131.63	3,346,195.59	474,346,312.13	634,242,639.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	179,723,100.0	177,073,565.5	2,649,534.5	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	179,723,100.0	177,073,565.5	2,649,534.5	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,723,100.0	177,073,565.5	2,649,534.5	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,153,200.0	137,151,310.0	1,890.0	100.0
210101	Үндсэн цалин	116,153,200.0	116,151,310.0	1,890.0	100.0

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210105	Гэрээт ажлын хөлс	21,000,000.0	21,000,000.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,346,300.0	18,180,864.4	165,435.6	99.1
210201	Тэтгэврийн даатгал	12,914,600.0	12,768,764.4	145,835.7	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,357,900.0	1,353,000.0	4,900.0	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,086,300.0	1,082,380.0	3,920.0	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	271,600.0	270,620.0	980.0	99.6
210205	Эрүүл мэндийн даатгал	2,715,900.0	2,706,100.0	9,800.0	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,432,200.0	11,950,291.2	2,481,908.8	82.8
210301	Гэрэл, цахилгаан	800,000.0	1,276,443.2	(476,443.2)	159.6
210302	Түлш, халаалт	11,582,200.0	8,779,240.0	2,802,960.0	75.8
210303	Цэвэр, бохир ус	2,050,000.0	1,894,608.0	155,392.0	92.4
2104	Хангамж, бараа материалын зардал	6,441,400.0	6,441,100.0	300.0	100.0
210401	Бичиг хэрэг	1,200,000.0	1,200,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.0	2,999,700.0	300.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,441,400.0	1,441,400.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.0	800,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.0	2,500,000.0	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.0	2,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	500,000.0	500,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.0	600,000.0	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.0	300,000.0	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.0	40,000.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,000.0	220,000.0	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.0	40,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.0	250,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.0	250,000.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	179,723,100.0	179,723,100.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	179,723,100.0	179,723,100.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	179,723,100.0	179,723,100.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	854,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	854,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	854,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	854,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	854,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	854,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 13-наас 2021 оны 01 дүгээр сарын 15–ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1/07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль дээдлэх, төрийн албаны шуурхай, тасралтгүй, чанартай байх зарчмыг чанд баримтлан, хууль журмыг сахин биелүүлж, иргэн бүрд хүнд сурталгүй төрийн үйлчилгээг бүргэж, багийн хэмжээнд төрийн байгууллагын манлайллыг хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын алба нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 212,005.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,120.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,369.7 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	6,986.9	3,634.7	-3352.3
Үндсэн хөрөнгө	788,884.7	857,595.5	68,710.8
Нийт хөрөнгө	617,566.1	635,935.8	18,369.7
Өр төлбөр	2,576.4	1,693.1	-883.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	614,989.6	634,242.6	19,253.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	617,566.1	635,935.8	18,369.7

Бараа материалын дансны үлдэгдэл 3,634.7 мянган төгрөг болж буурсан нь үндсэн хөрөнгийн шинжтэй 3,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө рүү шилжүүлсэн нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 788,884.7 мянган төгрөг болж өссөн нь автомашин, барилгыг балансаас баланс хооронд шилжүүлэн авсан нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 1,859.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 71,189.5 мянган төгрөгийн, нийт 81,975.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 13,264.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь аймгийн хөрөнгө оруулалтаар нэгдсэн байдлаар санхүүгийн программ, нярвын программ авч өгсөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,693.1 мянган төгрөг болж 883.3 мянган төгрөгөөр буурсан байгаа нь оны сүүлд халаалтын төлбөр хийгдээгүй 1,693.2 мянган төгрөгийн үлдэгдэл үлдсэн нь шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 634,242.6 мянган төгрөг болж 19,253.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашиг 19,252.7 мянган төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгө актлагдсан мөн элэгдэл хорогдол шалтгаалжээ.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 405,037.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй орлогоор материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь өмнөх онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар барилга орлогод авсан нь нөлөөлсөн байна

Нийт зардал өмнөх оноос 13,810.6 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал байна. Энэ нь . Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалин нэмсэн нь шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 179,723.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 179,723.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 179,723.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 179,723.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 179,723.1 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 177,073.6 мянган төгрөгийг зарцуулж 2,649.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 177,073.6 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардлыг 2,481.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх зардлыг 165.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 2,649.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Энэ нь тайлант оны эцэст халаалтын төлбөрийн гүйлгээг хийж чадаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 500.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 354.0 мянга, нийт 854.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газраас багийн зорилтод бүлгийн айл өрхүүдэд дэмжлэг үзүүлэх зардалд 500.0 мянга, бусад байгууллагын үйл ажиллагаанд 354.0 төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй 354.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж зарцуулсан байна

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12,042.2 мянган төгрөгийн зөрчилд 2,009.8 мянган төгрөгийн төлбөрийн актыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 2009,8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5174,2 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,009.8	2	2,009.8	0		
Албан шаардлага							
Зөвлөмж	3	5,174.2	3	5,174.2	0		
Нийт дүн							

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,397.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,581.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 625.3 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 91.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,100.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өмнөх оны аудитын зөвлөмжөөр үндсэн хөрөнгийн шинжтэй 3,600.0 төгрөгийн гадаа тайзыг бараа материалын дансанд бүртгэсэн байсныг залруулахдаа үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрсөн байсныг залруулсан.
2. Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн 854.0 мянган төгрөгийн орлогыг үр дүнгийн тайланд орон нутгийн татварын орлогын үзүүлэлтэд тайлагнасан байсныг залруулсан.

3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй авч өгсөн санхүүгийн болон нярвын 1,727.0 мянган төгрөгийн программыг данс бүртгэлд аваагүй байсныг залруулсан.
4. Тайлант онд гарсан 400.0 мянган төгрөгийн 7 ажил гүйлгээг шууд зардалд бичиж тайлагнасан байсныг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,816.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 625.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 91.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх нотариатын орлого болох 354.0 мянган төгрөгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйл 23.6.8-д *“аймгийн татварын орлого нь энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамжийн орлогоос бүрдэнэ”*, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

2. Ажилчдын ээлжийн амралтын цалингийн дундаж тооцохдоо унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан тооцсон нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйл 55.2-т *“Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно”*, Эрүүл мэндийн сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан *“Ээлжийн амралтын олговор тооцох журам”*-ын 3-т *“Ээлжийн амралтын олговрыг уг ажилтны ээлжийн амралт эдлэхээс өмнөх ажлын нэг жилийн хугацааны дундаж цалин хөлсийг үндэслэн тодорхойлно”*, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан *“Дундаж цалин хөлс тодорхойлох журам”*-ын 4-д *“Ажилтанд олгож байгаа бүр төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

3. Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны ажилласан хугацааны ээлжийн амралтын тооцоог бодоогүй нь Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйл 55.1-т *“Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд ээлжийн амралтын олговор олгоно”*, Эрүүл мэндийн сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт *“Ээлжийн амралт олгох заавар”*-ын 15-т *“Ажилтан ажлаас халагдах үед ажил олгогч нь түүнтэй ээлжийн амралтын тооцоог заавал хийнэ”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоосон

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,100.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны цалин, хөлсний тооцоололд аудитаар удаа дараалан алдаа зөрчил илэрч байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Хөрөнгийн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай зохион байгуулаагүй.
- 1.2. Эрсдэл: Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт суларч, төрийн өмч эзэнгүйдэх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа", 72 дугаар зүйл 4.1 "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дүүсгэх" 73 дугаар зүйл 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг түлгэн шалгана, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйл 5.1.4 "Үнэн зөв байх" гэж тус тус заасан байдаг тул байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай зохион байгуулж тооллогын акт материалаар баталгаажсан дүнгээр нягтлан бодох бүртгэлд тусгаж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дотоод хяналттай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэлгүй принтер 1 ширхэг, сейф 2 ширхгийг худалдан авсан байна.
- 2.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлтэй зарцуулахгүй байх.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-т "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйл 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн

хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-т "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйл 14.3-т "нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ" гэж тус тус заасан байдаг тул цаашид анхан шатны баримтгүй гүйлгээг хийхгүй байж худалдан авсан хөрөнгийн гэрэл зураг болон анхан шатны баримтыг хавсарган ирүүлэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			дга-2021/111/ста-тшз
Шалгагдсан байгууллагын нэр:	Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх нотариатын орлогыг зарцуулсан	354.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
2	Ажилчдын ээлжийн амралтын цалингийн дундаж тооцохдоо унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан тооцсон	271.3	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
3	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны ажилласан хугацааны ээлжийн амралтын тооцоог бодоогүй	91.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
4	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гаргасан	1,100.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч, нярав	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
5	Эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай зохион байгуулаагүй.	0.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч, нярав	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
ДҮН		1,816.9			